

МОНГОЛЫН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ХУВИЛБАРТ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ж. Батдэлгэр, профессор, БоСС

Abstract: This paper focuses on Alternative education, which is an integral part of Preschool education service in Mongolia. First, the author discusses when and how the Alternative Education service was established and its development stages. Then I show the importance of its role in contributing to access to preschool education, current problems and the ways of developing it. The article used quantative methods such as literature review, case studies. The secondary sources used to define the 3 stages of Alternative Education curriculum development between 1990-1999, 2000-2008 and 2008 till now and I defined the characteristics of each stage. In addition, I did a brief evaluation of the current situation of Alternative Training Mongolia in regards with structural approach.

Children of remote herders and migrated people who stay far from central rural area mainly involved in this Alternative Training. At the beginning stages, alternative training was supported by International organizations to improve access of Preschool education. As a result of approved pre - school education law in 2008, improving the legal environment, its quality and close attention to Alternative Training sustainable development by financing with national budget, Finally, the author concluded that Alternative Education service System had been created.

Түлхүүр үг: Сургуулийн өмнөх боловсрол, хувилбарт сургалт, хувилбарт сургалтын хөтөлбөр, ээлжийн бүлэг, явуулын багшийн сургалт, нүүдлийн гэр цэцэрлэг

Үндсэн хэсэг

Манай оронд 1920 оны эцсээр орон нутагт “улаан гэр”-үүд, клуб, хоршоолол, артелийн дэргэд анхны цэцэрлэг, хүүхэд саатуулах газрууд байгуулагдаж эл суурин дээр 1930 онд нийслэлд Д.Сүхбаатарын нэрэмжит коммуны дэргэд анхны цэцэрлэг байгуулагдсан. Карма “БНМАУ-ын хүүхдийн цэцэрлэгийн үүсэл, хөгжил” бүтээлдээ “...1931 онд орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг шинэчлэн тогтоож байсан үед Хэнтийн Өндөрхаан,Төвийн Тариалан, Өвөрхангайн төвийн Ламын гэгээний хийд, Улаанбаатарт хоёрын зэрэг газарт хүүхдийн цэцэрлэг шинээр нэмж байгуулжээ” гэжээ (Карма, 1983,х.12). Харин 1932 онд 14 цэцэрлэг нэмэгдэж улмаар хувьсгалын ардчилсан шатанд 1940 он гэхэд 50 шахам цэцэрлэгт 1400 гаруй хүүхэд хүмүүжиж байсан байна. Энэ нь манай оронд сургуулийн өмнөх боловсрол (цаашид СӨБ) -ын бүхэл бүтэн тогтолцоо хөгжих суурь нь болсон юм. Эл цаг үеэс хойш төр засаг, олон улсын байгууллагаас СӨБ-ыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж хөрөнгө оруулалтыг хийсний үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанар жилээс жилд сайжирч байна.

Эдүгээ Монгол улсын хэмжээнд 2013-2014 оны хичээлийн жилийн байдлаар нийт 1,067 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагааг явуулж байгаагаас төрийн өмчийн 764 цэцэрлэг, хувийн 303 цэцэрлэг байна. Хувийн цэцэрлэгийн 250 буюу 82,5 хувь Улаанбаатар хотод шинээр байгуулагджээ (Боловсролын салбарын 2013-2014 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл, 2014, х. 12).

Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн сургалтаас гадна СӨБ-д хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор төвөөс алслагдсан малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах зорилгоор 1990 оноос эхлэн хөдөө орон нутагт зун, намрын улиралд монгол гэрийг ашиглан гэр цэцэрлэгийг ажиллуулж эхэлсэн юм. Монгол гэр нь:

- малчид зун, намрын дулаан улиралд хаана олон хот айл буусан тэр газар нь барьж, буулгахад цаг хугацаа их шаардагдахгүй
- олдоцтой
- үнийн хувьд хямд төсөр бөгөөд хоёр гэрийг нийлүүлэн нэгд нь сургалт зохион байгуулж, нөгөөд нь хүүхдийг унтуулах, хооллох зэргээр ашигладаг.

Зуны гэр цэцэрлэгээс гадна нийслэл, аймаг, сумын төвд цэцэрлэгийн барилгыг ашиглан

сургуульд орох насны хүүхдийг сургуульд бэлтгэх зорилгоор “ээлжийн бүлэг”-ийг нээн ажиллуулжээ. Ийнхүү 1990-ээд оноос эхлэлтэй зуны гэр цэцэрлэг, ээлжийн бүлгийн сургалт нь боловсронгуй болсоор 2008 онд баталсан Сургуулийн өмнөх боловсролын хуульд “хувилбарт сургалт” хэмээн баталгаажиж СӨБ-ын тогтолцооны салшгүй нэг хэсэг болсон юм. Хуулийн нэгдүгээр бүлгийн 4.1.9-д “хувилбарт сургалт” гэж үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх “ээлжийн бүлгийн”, “явуулын багшийн”, “нүүдлийн бүлгийн” сургалтын үйл ажиллагаа “ хэмээн тодорхойлсон.

“...ээлжийн бүлгийн сургалт” гэж гэж боловсролын стандартыг баримтлан танхимын хэлбэрээр хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг,

“...явуулын багшийн сургалт” гэж боловсролын стандартыг гэр бүлд түшиглэн, хүүхдэд СӨБ эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг,


“...нүүдлийн бүлгийн сургалт” гэж боловсролын стандартыг баримтлан гэр бүл, хүүхдэд үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

2014 оны БШУЯ-ны статистикийн мэдээллээр хувилбарт сургалтад сургуулийн өмнөх насны хүүхдийн 25,794 буюу 13,3 хувь нь хамрагдаж байна. Үүнээс 6,591 хүүхэд ээлжийн бүлэгт, 15,931 хүүхэд нүүдлийн бүлэгт, 3272 хүүхэд явуулын багшийн үйлчилгээгээр дамжуулан СӨБ-ыг хүртэж байна. (Диаграмм 1)

Дээрх графикаас харахад, СӨБ-ын байгууллагын хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоог сүүлийн 10 жилийн байдлаас харахад, хамрагдсан хүүхдийн тоо 2007-2008 он хүртэл тасралтгүй өсөж байснаа 2008-2009 оны хичээлийн жилд 1,121-ээр буурч, 2009 оноос дахин нэмэгдэж байснаа сүүлийн 3 жилд дахин буурах хандлага ажиглагдаж байна.

Бид хувилбарт сургалтын түүхэн хөгжлийг үечлэн авч үзэхдээ дараах хоёрдогч эх үүсвэрийг ашигласан юм. Үүнд: Монгол улсын Засгийн газрын 1995 оны тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх боловсрол” үндэсний хөтөлбөр -1, 2001 онд баталсан “ Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөр-2”, Засгийн газрын 2006 оны 192-р тогтоолоор баталсан “Монгол улсын боловсролыг 2015 он хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”, “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008 он”, БШУЯ, Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгааны тайлан, олон улсын байгууллагуудын дунд хугацааны баримт бичиг, аймаг, нийслэлийн боловсролын газрын тайланг ашиглан баримт бичгийн судалгаа хийлээ.

Судалгааны үр дүнд хувилбарт сургалтын хөгжлийг 1990-1999 он, 2000- 2008 он, 2008-аас одоо хүртэл хэмээн гурван үе шат болгон авч үзэж болохоор байна. Үе шат тус бүрийн онцлогийг хүснэгт №1- д үзүүлэв.



Эх сурвалж: Боловсролын салбарын 2013-2014 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (I), 2014, Улаанбаатар, х.12

Хүснэгт 1

Хувилбарт сургалтын хөгжлийн үе шат, онцлог

Он	Үе шат	Онцлог	Үр дүн
1995-2000	Хувилбарт сургалт үүсч бий болох үе	1990-ээд онд Монгол улс зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжих үед боловсролын салбарт хямрал нүүрлэж, энэ нь СӨБ-д нөлөөлж СӨБ-ын хүртээмж буурч, ялангуяа төв суурин газраас алслагдмал малчин өрхийн болон ядуу, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд СӨБ-д хамрагдаж чадахгүй байсан. Энэ нь хүртээмжид нөлөөлсөн хүчин зүйлийн нэг байв. Энэ эгзэгтэй үед МУ-ын Засгийн газраас “Сургуулийн өмнөх боловсрол-үндэсний хөтөлбөр -1,2 (1995), (2001) - ыг баталсан. Хөтөлбөрийн нэг чухал зорилт бол цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа нийгмийн эмзэг хэсгийн болон малчин өрхийн хүүхдүүдэд зориулсан цэцэрлэгээс бусад хэлбэрийн сургалтыг хөгжүүлэх, хүртээмжийг сайжруулж санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. “Сургуулийн өмнөх боловсрол-2” хөтөлбөрт “... сургалтын олон хувилбарт үр ашигтай хэлбэрийг нэвтрүүлж, сургуулийн өмнөх үйлчилгээний оновчтой тогтолцоо бүрдүүлнэ” хэмээн заажээ (6 дахь тал). Засгийн газрын энэ шийдвэрийг хэрэгжүүлэхэд Английн Хүүхдийг Ивээх сан санхүүгийн болон техникийн тусламж үзүүлжээ. Анх Баянхонгор аймагт төслийн хэлбэрээр хэрэгжүүлсэн. Нийслэл болон зарим суурин газруудад бага насны хүүхдэд зориулсан тоглоомын төв, оюун ухаан, бие бялдар, урлагийн авъяас чадварыг хөгжүүлэх төрөлжсөн клуб, богино хугацаанд хүүхдийг уншиж, бичүүлж сургах төрөлжсөн хэлбэрийн үйлчилгээ бий болсон.	Цэцэрлэг хүрэлцэхгүйгээс төв суурин газраас алслагдмал малчин өрхийн, ядуу, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байсан тэр үед хүүхдийг сургуульд бэлтгэх зорилгоор цэцэрлэгийн барилга болон гэрийг ашиглан богино цагаар сургалтыг зохион байгуулж, хүүхдийг сургуульд бэлтгэж байсан. Энэ үеэс ээлжийн бүлэг, түр сургалт, гэр цэцэрлэг хэмээх ойлголт бий болж хувилбарт сургалтын суурь тавигдсан. Эхэн үед гол төлөв олон улсын байгууллагууд (Английн хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн олон улсын байгууллага гэх мэт) санхүүгийн дэмжлэг үзүүлж байв.

2000-2008	Туршлага хуримтлах хөгжлийн үе шат.	2003-2007 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн Ядуурлыг бууруулах хөтөлбөр төслийн хүрээнд 4 аймагт гэр өгч төслөөс гэр цэцэрлэг ажиллуулах зардал, хүүхдийн хоолны мөнгө, ариун цэвэр, хичээлийн хэрэгслийг дааж байв. НҮБ-ын Нийгмийн цогц суурь үйлчилгээ “ төслийн хүрээнд Өмнөговь, Хэнтий, Увс аймагт хувилбарт сургалтыг хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэр цэцэрлэг, түүний тоног төхөөрөмжийг өгөхөөс гадна багш нарыг чадавхижуулахад үлэмж анхаарчээ. Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын Боловсролыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-нд Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 99 хувьд хүргэх зорилгын хүрээнд “цэцэрлэгийн ээлжийн, улирлын, түр сургалтын үйлчилгээг өргөжүүлэх, орон нутагт малчдын хүүхдийн хөгжлийг хангах гэр бүл төвтэй явуулын, улирлын, эцэг эхийн, зайны сургалтын үйлчилгээг бий болгох, малчдын хүүхдэд зориулсан гэр бүлд тулгуурласан үйлчилгээний стандарт, сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулан мөрдөх, багшийг давтан бэлтгэх зорилтыг дэвшүүлсэн. Түүнчлэн сургалтын, багшийн цалингийн асуудлыг шийдвэрлэх, СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хөдөөгийн болон хотын захын хорооллын нэн ядуу айл өрхийн хүүхдүүдэд зориулсан олон хувилбарт үйлчилгээг бий болгох үйл ажиллагааг өргөжүүлэхээр тусгасан байна.	Олон улсын төсөл, хөтөлбөр нь монгол улсын олон аймаг, сумыг хамрах болсноор хувилбарт сургалтын хэлбэрийн тоо, түүнд хамрагдагчдын тоо өмнөх жилүүдтэй харьцуулахад ихээхэн нэмэгдсэн. Хувилбарт сургалтын багшийг давтан бэлтгэж тэдгээрийн цалингийн асуудлыг төрөөс шийдвэрлэсэн. Хөдөө орон нутгаас гадна хотын захын хорооллын СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах иргэд, олон нийтийн санаачлаг бий болсон бөгөөд түүнийг нь төр засгаас дэмжсэн.
2008-өнөөг хүртэл	Хувилбарт сургалтыг тогтолцоо бий болсон үе	Монгол улсын УИХ-аас 2008 онд баталсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулиар хувилбарт сургалтыг эрх зүйн хувьд баталгаажуулсан. Хуульд “...хувилбарт сургалт”, “ээлжийн бүлэг”, “нүүдлийн бүлэг”, явуулын багшийн сургалт” хэмээн хувилбарт сургалтыг зохион байгуулах хэлбэрийг тогтоон баталгаажуулсан. “Цэцэрлэг нь СӨБ эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн багш ажиллуулна “ /7 дахь тал / заалт нь багшлах боловсон хүчний асуудлыг шийдэж өгсөн юм. Түүнчлэн “...явуулын багш, ээлжийн болон нүүдлийн бүлгийн сургалтын нэг хүүхдэд ногдох зардлаар тооцон улсын төсвөөс санхүүжүүлнэ” /11 дэх тал / хэмээн заажээ. 2010 оны 5 сард БШУ-ны сайдын тушаалаар Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журмыг баталсан.	Хувилбарт сургалтын хөтөлбөртэй болж, улсын төсвөөс санхүүжилтийг өгөх болсон. Ийнхүү хувилбарт сургалт нь сургалтын агуулга, аргазүй, орчин, багшлах боловсон хүчин, санхүүжилтийн эрх зүйн баталгаатай болсон нь хувилбарт сургалтын бүхэл бүтэн тогтолцоо бий болсон үе гэж үзэж байна.
		БШУ-ны сайдын 2012 оны 11 сарын 20-ны өдрийн А/131 тушаалаар СӨБ эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журмыг баталсан. Журмаар хувилбарт сургалтын зохион байгуулалт, санхүүжилт, хяналт-үнэлгээ, сургалтын үйлчилгээний шалгуур, үзүүлэлтийг нарийвчлан журамлаж өгсөн.	

Дээрх баримтын судалгаанд хийсэн шинжилгээнээс харахад, 2008 оноос өмнө СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг хамруулах зорилгоор хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувилбарт сургалт ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Харин 2008 оноос хойш эрх зүйн орчинг бий болгосны үр дүнд

хувилбарт сургалтын тогтолцоо бий болж чанарыг сайжруулахад үлэмж анхаарсан нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хувилбарт сургалтын хөтөлбөр, ном гарын авлага, багшлах боловсон хүчин хийгээд санхүүгийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэсэн байна. (Хүснэгт № 2)

Хүснэгт 2

Шинэчлэлтийн хэрэгжилтийн үр дүн

№	Тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг	Агуулга
1	Зорилго	Цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа төв, суурин газраас алслагдсан, малчдын болон шилжин суурьшсан иргэдийн бага насны хүүхдийн эсэн мэнд бойжих, эрүүл байх, сургуульд бэлтгэх, хөгжих хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулснаар эрүүл өсөж бойжих, орчноо сонирхох, сониуч занг хөгжүүлэх, санаа бодлоо илэрхийлэх, бусадтай харилцах чадвартай иргэн болж төлөвших суурийг тавихад чиглэсэн.
2	Эрхзүйн орчин	Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын Боловсролыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, УИХ-аас 2008 онд баталсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд хувилбарт сургалт зохион байгуулах эрхзүйн орчин баталгаажсан.
3	Хүүхдийн насны хязгаар	2-5 насны хүүхэд хамрагдана.
3	Агуулга	Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын хөтөлбөрийг 2000, 2008, 2013 онд боловсронгуй болгож сайжруулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор багш, эцэг эхэд зориулсан гарын авлага, зөвлөмжийн тоо олширсон. Мөн зайны сургалтын DVD, цахим хичээлүүдийг бэлтгэж эхэлсэн.
4	Зохион байгуулалт, түүний хэлбэр	Хувилбарт сургалтыг зохион байгуулах журам батлагдсанаар хувилбарт сургалтын хэлбэр, агуулгын хэмжээ, багшлах боловсон хүчин, хяналт-үнэлгээ нарийвчлагдан тодорхой болсон. Тухайлбал, Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн хүүхдийн цэцэрлэг хувилбарт сургалтыг зохион байгуулна. Хувилбарт сургалтын цагийн жишиг доод хэмжээ, сургалт зохион байгуулах жишиг хугацаа, нэг хүүхдэд ноогдох сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын багцыг тодорхой болгож өгсөн.
5	Хүний нөөц-боловсон хүчин	СӨБ-ын мэргэжлийн багшаас гадна журамд зааснаар доод тал нь 72 цагийн агуулга бүхий сертификатын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан багш зохион байгуулахаар болсон.
	Сургалтын хяналт-үнэлгээ	Жил бүр аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлнэ.
6	Сургалтын орчин	Гэр цэцэрлэгийн орчны стандарт байхгүй ч хувилбарт сургалт явуулах цэцэрлэгийн танхим болон гэрт 15 хүүхдийн дунд нэг гар угаалтуур, 8-10 хүүхдийн дунд нэг суултуур ноогдоно. Зуны гэр цэцэрлэг нь хүүхдийн тоогоор ширээ сандал, ангийн самбар, тоглоомтой. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөр гэр цэцэрлэгт нийлүүлсэн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг эс тооцвол гол төлөв цэцэрлэгийн үндсэн сургалтад хэрэглэдэг тоглоомыг хувилбарт сургалтад ашигладаг байна.
7	Санхүү	Явуулын багш, ээлжийн болон нүүдлийн бүлгийн сургалтын зардлыг нэг хүүхдэд ногдох зардлаар тооцон улсын төсвөөс жил бүр санхүүжүүлдэг болсон.

Хувилбарт сургалт нь нийслэл, аймаг, сумын онцлогоос шалтгаалан нийслэл, аймгийн төвд ээлжийн бүлэг, цагийн сургалт, сумын төв,

багуудад явуулын багш, зуны нүүдлийн гэр цэцэрлэг, тайгад урцан цэцэрлэгийн хэлбэрээр хэрэгжиж байна.

Манай баруун тайгын хүүхдүүд сумын төвөөс маш алслагдмал, цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй. Манай энд Урцан цэцэрлэг байгуулагдаж түүнд зээ охин минь явдаг. Охиноо 6 км-ээс өдөр бүр цэцэрлэгт нь хүргэж ирдэг. Холоос ирэхэд хэцүү байдаг ч бид үүнийг бэрхшээл гэж үзэхгүй байна. Учир нь зээ охин маань зураг зурж, тоолж, дүрс эвлүүлж сурсан. Сайн хүн болж байгаа. Олон дуу, шүлэг мэддэг, цэцэрлэгт явахаас өмнө өвөө, эмээ, ээж аавтайгаа л харилцдаг байсан одоо олон найзтай болж бодол санаагаа чөлөөтэй илэрхийлж, хувцсаа өөрөө эвхээд тавьдаг, өдөр бүр мэндэлж, бас баярлалаа гэдэг үгийг байнга хэлдэг болоод байна.

Баруун тайгын Цагаан нуур сумын багийн урц цэцэрлэгт хүмүүжиж буй 5 настай Н.Б-ийн өвөөгийн ярианаас

Баримтын судалгаанд хийсэн дүн шинжилгээнээс харахад Монгол улсад хувилбарт сургалтын тогтолцоо үүсэн бий болжээ. Хувилбарт сургалтад гол төлөв төв суурин газраас алслагдсан малчин өрхийн болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүд хамрагдаж байна. Анх хувилбарт сургалтыг явуулахад олон улсын байгууллага санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлдэг байсан бөгөөд үндсэн зорилго нь төв, суурин газраас алслагдмал малчдын хүүхдийг хамруулах замаар СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаардаг байв. 2008 оноос оноос сургуулийн өмнөх боловсролын хууль батлагдсанаас хойш хувилбарт сургалтын эрхзүйн орчин бүрдсэнээр хувилбарт сургалтын чанарыг сайжруулах, улсын төсвөөс санхүүжүүлэх замаар хувилбарт сургалтыг тогтвортой хөгжүүлэхэд анхаарч байна. Өдгөө хувилбарт сургалт нь СӨБ-ын тогтолцооны салшгүй нэг хэсэг болон хөгжиж байна. Тоон статистик дүн шинжилгээнээс харахад, сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувилбарт сургалт чухал үүргийг гүйцэтгэж байна.

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2012).

Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 11 сарын 20-ны өдрийн А/131-р тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журам”. Улаанбаатар

Карма, Э., Лхагвасүрэн, Ж. (1983). *БНМАУ-ын хүүхдийн цэцэрлэгийн үүсэл, хөгжил*. Улаанбаатар: Ардын боловсролын яамны хэвлэл

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам., Japan Find for Poverty Reduction. (2012). Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын хөтөлбөр. Улаанбаатар

"Боловсролын судалгаа инновацийн хөгжил" эмхэтгэл. 2015

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Их хурал. (2009). Сургуулийн өмнөх боловсролын тухай. Улаанбаатар

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2007). *Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө*. Улаанбаатар

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2014). *Боловсролын салбарын 2013-2014 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (I)*. Улаанбаатар

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2014). *Боловсролын салбарын 2013-2014 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл (II)*. Улаанбаатар